



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/1104

Улаанбаатар хот

Цэргийн дүйцүүлэх алба хаагчдийн албаны бэлтгэл шатны сургалтыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолын хавсралтын 4 дэх хэсэг, 2022 оны 279 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 44 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/469 дүгээр захирамж, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2023 оны А/22 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн дүйцүүлэх албыг 2023-2025 онд биеэр дүйцүүлэх хаах хүсэлт гаргаж элссэн алба хаагчдыг "Цэргийн албаны бэлтгэл шатны нэгдсэн сургалт"-д оролцуулах, иргэдийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг ханган 2023 оны 06 дугаар сарын 02 - ноос 15-ны өдрүүдэд хамруулахыг Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

2.Сургалтад хамрагдах бэлтгэл үүрэгтнүүдийн нэрийн жагсаалтыг нэгдүгээр, сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Цэргийн албаны бэлтгэл шатны сургалтыг зохион байгуулахад шаардагдах 1,237,200 (Нэг сая хоёр зуун гучин долоон мянга хоёр зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Цэргийн албаны бэлтгэл шатны сургалтад бие бүрэлдэхүүнийг бүрэн хамруулан, осол зөрчилгүй зохион байгуулж, тайлан, мэдээг журамд заасан хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлэх, сургалтын дүнгийн талаар 2023 оны 06 дугаар сарын 16-нд тайлагнахыг Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үйл ажиллагааг зохион байгуулж дүнг 5 хоногийн дотор танилцуулж, зарцуулсан санхүүгийн тайланг ирүүлэхийг Цэргийн штаб (дэд хурандаа Ш.Бат-Өлзий)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

1123000303

А.Д. 2023 он ажил захирамж